

УИХ-ЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАНГИЙН КАНАДАД ХИЙСЭН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ

УИХ-ын дарга Д.Лүндээжанцан тэргүүтэй төлөөлөгчид 2007 оны арванхоёрдугаар сарын 1-8-ны өдрүүдэд Канадын парламентын Нийтийн танхимын спикер П.Милликений урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийлээ. УИХ-ын дарга Д.Лүндээжанцан Авлигатай тэмцэх дэлхийн парламентчдын байгууллага /ГОПАК/-ын тэргүүн, Канадын парламентын гишүүн Жон Вильямтай уулзсанаар айлчлалын албан ёсны хөтөлбөр эхэлсэн бөгөөд уулзалтын үеэр Монгол Улс ГОПАК-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, энэ хүрээнд УИХ дахь үндэсний бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ГОПАК-ийн олон улсын хөтөлбөрт хамрагдаж ажиллах болон 2008 оны нэгдүгээр сарын 29-нд Индонез улсын Балид болох Авлигын эсрэг олон улсын бага хурлын талаар ярилцаж, ноён Жон Вильям Монголын парламентчдын төлөөлөгчдийг уг бага хуралд оролцохыг албан ёсоор урьсан байна.

Тус байгууллагын тэргүүн Монгол Улстай бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах сонирхолтой байгаагаа мэдэгдсэн бол УИХ-ын дарга Д.Лүндээжанцан Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтуудаа тодорхойлохдоо хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх талаарх зорилтуудыг нэмж тусгасныг дурдаж энэ чиглэлээр ГОПАК-тай нягт хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлээд Монголын парламентын зүгээс авлигатай тэмцэх талаар хийсэн алхам, тухайлбал Авлигатай тэмцэх хууль баталсан, Авлигатай тэмцэх газар байгуулсан, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид элссэн талаар танилцууллаа.

ГОПАК буюу Авлигатай тэмцэх дэлхийн парламентчдын байгууллага нь 2002 онд Оттавад болсон олон улсын парламентчдын бага хурлын үеэр байгуулагдсан ба сайн засаглалыг дэмжих, авлигатай тэмцэхэд хамтран ажиллахад тус байгууллагын гол зорилго оршино. Байгууллагуудын Захирлуудын Зөвлөл нь ГОПАК-ийн бүс нутгийн бүлгийн гишүүдээс бүрдэж, ГОПАК-ийн Гүйцэтгэх хороог сонгоно. Гүйцэтгэх хороо нь тус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулдаг. Уг байгууллага одоогоор 90 гаруй орны 900 гаруй парламентын гишүүнтэй бөгөөд нарийн бичгийн дарга нарын газар нь Оттавад байрлалтай.

Айлчлалын үеэр манай төлөөлөгчид Канадын парламентын Сенатын танхимын спикер ноён Ноэл Кинселлатай уулзаж УИХ-ын дарга улс орныхоо улс төр, эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдлын талаар товч танилцуулаад Монгол Улс харилцан тохиролцсон ёсоор “өргөн хүрээтэй түншлэл”-ийн хүрээнд хоёр талын харилцаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийн төлөө байгаагаа нотлов.

Мөн тэрээр хоёр орны хамтын ажиллагааг цаашид улам өргөжүүлэх талаар саналаа илэрхийлэхдээ Монгол, Канадын хамтын ажиллагаанд уул уурхайн салбарт оруулж буй Канадын хөрөнгө оруулалт голлох үүрэг гүйцэтгэж байгааг дурдаад, хамтын ажиллагааг байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлал, зам тээвэр, барилга хот байгуулалт зэрэг өөр бусад олон салбарт түлхүү хөгжүүлэх, туршлага судлах сонирхолтой байгааг тэмдэглэв.

Мөн тэрбээр Монгол Улс Канадын тарифын хөнгөлөлтийн системд бараа бүтээгдэхүүнийхээ нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг худалдаа, хөрөнгө оруулалтаас гадна үйлчилгээний салбарт өргөжүүлэх сонирхолтой байна гээд Канадын хөгжлийн албан ёсны тусламж /ХАЁТ/ олгодог орнуудын жагсаалтад хамрагдах, буурай хөгжилтэй орнуудын өрийн дарамтыг бууруулах олон талт санаачилгын хүрээнд Монгол Улсад дэмжлэг үзүүлэхийг хүсэв.

Тэрээр цааш нь Монгол Улсад өндөр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх хэрэгцээ шаардлага өндөр байгааг онцлоод, энэ хүрээнд холбогдох байгууллагууд харилцан тохиролцох, хоёр орны их дээд сургуулиудын харилцаа холбоог гүнзгийрүүлэх талаар ажиллаж болох юм гэлээ. Ноён Н.Кинселла Монгол Улсын хөгжлийн явцыг анхааралтай ажиглаж байдгаа дурдаад Монголын залуучуудыг Монголд хөрөнгө оруулагч Канадын компаниудын хөрөнгөөр Канадын их дээд сургуулиудад сургах боломжтой талаар ярилаа.

УИХ-ын дарга Д.Лүндээжанцан уулзалтын үеэр хоёр орны харилцаа хамтын ажиллагаа эрчимтэй өргөжиж байгааг харгалзан Канад улс Монгол Улсад Элчин сайдын яамаа нээнэ гэдэгт найдаж байгаагаа хэлээд Канадын парламентын Сенатын танхимын спикер ноён Н.Кинселлаг тааламжтай үедээ Монгол Улсад айлчлахыг урилаа.

Мөн манай төлөөлөгчдийг Алконкуйн коллежийн ерөнхийлөгч ноён Роберт Гиллет хүлээн авч уулзаж сургуулиа танилцууллаа. Уг сургууль нь орчин үеийн технологийн сургалтаар улсдаа тэргүүлэх сургуулийн нэг бөгөөд дэвшилтэт технологи, бизнес эрүүл ахуй, мэдээлэл, загвар, аялал жуулчлал, цагдаа, зам, барилгын зэрэг олон мэргэжлээр боловсон хүчин бэлтгэн гаргадаг юм байна. Коллежийн ерөнхийлөгч Монголын ижил төрлийн сургуулиудтай хамтран ажиллахад бэлэн байгаагаа УИХ-ын даргад илэрхийлжээ.

УИХ-ын дарга Д.Лүндээжанцан Канадын парламентын нийтийн танхимын спикер П.Милликентэй уулзаж ярилцсан байна. Тэд хоёр талын харилцаа хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхэд өндөр дээд хэмжээний албан ёсны айлчлалууд чухал ач холбогдолтойг дурдахын зэрэгцээ хоёр орны парламент хоорондын хамтын ажиллагаа өргөжин тэлж энэ хүрээнд хоёр улсын парламент дахь найрамдлын бүлгүүд идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийллээ.

Мөн манай төлөөлөгчид Канадын парламент дахь Олон улсын парламентын холбооны бүлгийн ахлагч, Сенатын гишүүн Дональд Оливер,

Гадаад хэргийн асуудал эрхэлсэн парламентын нарийн бичгийн дарга Дипак Обхрайтай тус тус уулзав. Уг уулзалтын үеэр хоёр орны парламентын төлөөлөгчид Олон улсын парламентын шугамаар хамтран ажиллаж ирснийг харилцан тэмдэглээд, цаашид ч харилцан дэмжиж ажиллахаа хоёр тал илэрхийллээ. Энэ хүрээнд 2010 онд болох Олон улсын парламентын холбооны ээлжит хурлыг Канад улсад зохион байгуулах хүсэлтээ холбогдох байгууллагад уламжилсан бөгөөд түүнийг Монгол Улс дэмжихийн сацуу Монгол Улс ОУПХ-ны ээлжит хуралдааныг өөрийн оронд зохион байгуулах боломжтой талаар уулзалтын үеэр ярилцлаа.

УИХ-ын дарга Д.Лүндээжанцан тэргүүтэй төлөөлөгчид Канадын барилгын эрдэм шинжилгээний хүрээлэнд зочиллоо. Хүрээлэнгийн албаны хүмүүс байгууллагынхаа үйл ажиллагааны талаар товч танилцуулав. Манай улсын холбогдох яам тамгын газрууд тус хүрээлэнтэй хамтран хүйтний улиралд тэсвэртэй, эрчим хүчинд хэмнэлттэй Канадын барилгын стандартыг нэвтрүүлэх, загвар судлах зэргээр хамтран ажиллаж байгаа төдийгүй Канадын модон байшин барих технологийг ашиглан Улаанбаатар хотноо туршилтын шугамаар байшин барьж эхлээд байгаа юм байна.

Мөн манай төлөөлөгчид Торонто дахь Канадын зарим уул уурхайн компанийн төлөөлөгчидтэй уулзлаа. Уулзалтад оролцогсод Монгол Улсад Канадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр ашгийг нь дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хууль эрх зүйн тогтвортой орчинг бий болгох талаар санал солилцсон байна.

УИХ-ын дарга Д.Лүндээжанцан тэргүүтэй төлөөлөгчдийн Канад улсад хийсэн албан ёсны айлчлал нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал түлхэц өгөхүйц айлчлал болсон юм.

*Мэдээ бэлтгэсэн Д.Өэлүн-Үжин (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан)*